



БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/07

Хөхбүрд

Орон нутгийн хөгжлийн сангийн
санхүүжилтээр өвс худалдан авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5 заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд өвсний нөөц бүрдүүлэлт бага, нийт нутаг дэвсгэрийн 80% нь нэн их эрсдэлтэй 20% нь их эрсдэлтэй байгаа тул орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх зардлын дагуу сайн чанарын нарийн өвс худалдан авч өвсний нөөц бүрдүүлсүгэй.

2.Өвсний үнэ 36.400.000 (Гучин зургаан сая дөрвөн зуун мянган) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр олгохыг Сан хариуцсан нягтлан бодогч (Э.Мөнх-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

3.Өвсний нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулан, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч (Г.Ганцоож)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ж.ХАТАНБААТАР



642201163